



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 10 сарын 10 өдөр

Дугаар 223

Улаанбаатар хот

Хуваарьт өөрчлөлт оруулах тухай

Төсвийн ерөнхийлөн захирагчдаас ирүүлсэн саналыг харгалзан Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.13 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Сангийн сайдын 2014 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 123 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Монгол Улсын 2014 оны төсвийн зарлага, санхүүжилтийн сар, улирлын хуваарь"-ийн Монгол Улсын ерөнхий аудитор, Үндсэн хуулийн цэцийн дарга, Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Авлигатай тэмцэх газрын дарга, Гадаад харилцааны сайд, Сангийн сайд, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Соёл, спорт, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайд, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Хууль зүйн сайд, Батлан хамгаалахын сайд, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд, Хөдөлмөрийн сайдын багцын санхүүжилтийн сар, улирлын хуваарийг 1 дүгээр хавсралтаар, мөн тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Улсын төсвөөс 2014 оны төсвийн жилд орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг"-ийн хуваарийг 2 дугаар хавсралтаар, мөн тушаалын 5 дугаар хавсралтаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд олгох орлогын шилжүүлгийн сар, улирлын хуваарь"-ийг 3 дугаар хавсралтаар, мөн тушаалын 6 дугаар хавсралтаар батлагдсан "Улсын төсвөөс 2014 оны төсвийн жилд орон нутагт олгох тусгай зориулалтын шилжүүгийн сар, улирлын хуваарь"-ийг 4 дүгээр хавсралтаар, мөн тушаалын 9 дүгээр хавсралтаар батлагдсан "Монгол Улсын 2014 оны төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн сар, улирлын хуваарь"-ийг 5 дугаар хавсралтаар, мөн тушаалын 10 дугаар хавсралтаар батлагдсан "Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн сар, улирлын хуваарь"-ийг 6 дугаар хавсралтаар, Сангийн сайдын 2013 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 303 дугаар тушаалын 11 дүгээр хавсралтаар батлагдсан "Хүний хөгжил сангийн 2014 оны төсвийн сар, улирлын хуваарь"-ийг 7 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

Хоёр. Санхүүжилтийг шинэчилсэн хуваарийн дагуу олгохыг Төрийн сангийн газар /Ч.Тавинжил/-т зөвшөөрсүгэй.

САЙД



Ч.УЛААН

000501